

БАТЛАВ:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА *Ж. ГАНБААТАР*

2022 оны 10 дугаар сарын 14

УДИРДАМЖ

2022 оны 10 дугаар сарын 14

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт,
захиргааны байгууллагын үйл ажиллагаанд
хяналт-шинжилгээ хийх, ажлын үр дүнг
үнэлэх тухай

Зорилго: Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөн туслах

Хугацаа: 2022 оны 11 дүгээр сарын 01-05

Ажиллах багийн бүрэлдэхүүн:

Ажлын хэсгийн ахлагч:	Ц.Ганчимэг	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга
Гишүүд:	Т.Бямбадулам	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
	Д.Мягмарбаатар	Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн
	Ж.Даваасүрэн	Тогтвортой амьжиргаа-3 төслийн орон нутгийн ажилтан

Хамрах хүрээ: Дадал, Баян-Адарга, Биндэр, Норовлин, Баян-Овоо сумдын ЗДТГ, төсөвт байгууллагууд

Хяналт- шинжилгээнд хамрагдах асуудлын чиглэл:

1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн төлөвлөлт, хэрэгжилт
2. Бодлогын баримт бичгийн төлөвлөлт, хэрэгжилт
3. Төрийн байгууллагуудад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байдал
4. Байгууллагын болон төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хоорондын уялдаа
5. Захирамж, тушаалын эрх зүйн үндэслэлийг хянаж, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж, зөвлөн туслах
6. Архив, албан хэрэг хөтлөлт
7. Төсвийн орлогын биелэлт

8. Сумын удирдлагууд болон гүйцэтгэгч компаниудтай уулзалт хийж, тухайн суманд баригдаж байгаа барилга, объектын гүйцэтгэлийн явцтай танилцаж ашиглалтад орох эцсийн хугацааг объект тус бүрээр тодорхойлон жагсаалт үйлдэх
9. Khentii.mn сайтад үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг цаг тухай бүрт оруулсан эсэх
10. Үнэлгээний төхөөрөмжийн хэрэгжилт /бичлэг ухрааж үзэх бөгөөд илэрсэн зөрчлийн дагуу шууд арга хэмжээ тооцох/
11. Байгууллагын үйлчилгээний стандартын хэрэгжилт /төсөвт бүх байгууллага/
12. Хяналтын хуудасны журмын хэрэгжилт /төсөвт бүх байгууллага/
13. ОНХС-ийн 2022 оны үр дүнг танилцуулж, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чиглэлээр сургалт зохион байгуулах /Багийн Засаг дарга нар болон сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдийг хамруулах/

Анхаарах асуудал:

- Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол болон аймгийн Засаг даргын 2021 оны А/105 дугаар захирамжаар баталсан журам, аргачлалын дагуу үнэлж дүгнэн үнэлгээ өгнө.
- Ажлын хэсгийг ажиллах үед хяналт-шинжилгээнд хамрагдах асуудлаа бүрэн хамруулж хариуцсан албан хаагчаа бэлэн байлгаж оролцуулахыг тухайн байгууллагын удирдлага хариуцна.
- Дүнгийн хуралд нийт албан хаагчдыг бүрэн хамруулна.
- Хяналт-шинжилгээний дүнг удирдлагын зөвлөлд ажлын 7 хоногт багтаан танилцуулж, дүгнэлт зөвлөмж хүргүүлнэ.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС